**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 3 дугаар сарын 28-ны
өдөр

Улаанбаатар хот

**Дугаар 99**

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Цагдаагийн алба хаагчийн төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ыг 1 дүгээр, “Цагдаагийн алба хаагчдад албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг 2 дугаар, ”Цагдаагийн албан тушаалын цолны нэмэгдлийн хувь хэмжээ”-г 3 дугаар, “Цагдаагийн алба хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай./Энэ тогтоолын 3-р хавсралтад ЗГ-ын 2014 оны 126-р тогтоолоор өөрчлөлт орсон /

2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын энгийн орон тоонд шилжин ажиллах алба хаагчид төрийн тусгай алба хаасан хугацааны, цагдаагийн албан тушаалын цолны нэмэгдэл, албан ажлын онцгой нөхцөлийн, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг хэвээр тооцож, энгийн орон тоонд шинээр орох ажилтанд цалин хөлсийг “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 78 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээгээр тооцон олгосугай.

3. Цагдаагийн албан тушаалын цолны ангилал, зэрэглэлийн дагуу цол буурч байгаа алба хаагчдын цолны нэмэгдлийн хувь хэмжээг цалингийн сандаа багтаан бууруулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч, 2015 оноос эрхэлж байгаа албан тушаалын цалин хөлсийг тооцон олгохыг Цагдаагийн ерөнхий газрын дарга Б.Билэгтэд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Цэргийн цолны цалингийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 1999 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 38 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн “цагдаагийн болон” гэснийг, “Журам батлах тухай” (Цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын болон дотоодын цэргийн алба хаагчдад төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам) Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн “цагдаа”, “болон дотоодын цэргийн” гэснийг, мөн тогтоолын хавсралтын 1 дүгээр зүйлийн “цагдаа”, “болон дотоодын цэргийн” гэснийг тус тус хассугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 212 дугаар тогтоолыг, “Цагдаагийн алба хаагчдад зарим нэмэгдэл олгох журам батлах тухай” Засгийн газрын 2005 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 243 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.АЛТАНХУЯГ

Хууль зүйн сайд Х.ТЭМҮҮЖИН

Засгийн газрын 2014 оны 99 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

# ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ТӨРИЙН ТУСГАЙ АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Цагдаагийн алба хаагчид төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

| **Төрийн алба хаасан хугацаа (жилээр)** | **Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ (хувиар)** |
|---|---|
| 5-10 | 10 |
| 11-17 | 15 |
| 18 ба түүнээс дээш | 20 |

2. Төрийн албанд ажилласан хугацааг тогтоох үндсэн баримт, албан хаагчийн хувийн хэрэг, нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн дэвтэр байна.

3. Төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг бодохдоо алба хаагчийн ажилласан жилийн нэмэгдлийг нэмж тооцно.

4. Төрийн тусгай алба хаасан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно:

4.1. төрийн тусгай албанд ажилласан;

4.2. төрийн тусгай албанд ажиллах хугацаандаа байгууллагын захиалгаар дотоод, гадаадын сургууль, мэргэжил дээшлүүлэх дамжаа, адьюнктур, магистрантур, докторантурт суралцсан;

4.3. төрийн тусгай албанд ажиллах хугацаандаа жирэмсний, амаржсаны болон өвчний учир чөлөөтэй байсан.

----oOo----

Засгийн газрын 2014 оны 99 дүгээр

тогтоолын 2 дугаар хавсралт

## ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДАД АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Цагдаагийн алба хаагчид төрийн тусгай алба хааж байх хугацаанд албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг дараах албанд ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно:

| № | Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох нэгж | Нэмэгдлийн хэмжээ (үндсэн цалингийн хувиар) |
|---|---|---|
| 1 | Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн болон техникийн алба, Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлыг хангах алба | 25 |
| 2 | Цагдаагийн байгууллагын Дэмжлэг үзүүлэх алба, Сургалт дадлагын төв, Интерполын үндэсний товчоо | 20 |
| 3 | Бусад алба, төрийн захиргааны албан тушаалтан | 15 |

3. Цагдаагийн алба хаагчид олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн байгууллагын төсвөөс олгоно.

4. Цагдаагийн алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг өвчтэй, чөлөөтэй байх хугацаанд нь олгохгүй.

----oOo----

Засгийн газрын 2014 оны 99 дүгээр

тогтоолын 3 дугаар хавсралт

**ЦАГДААГИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦОЛНЫ**

**НЭМЭГДЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ**

| **Цагдаагийн албан тушаалын цолны ангилал** | **Цагдаагийн цол** | **Сар бүр олгох нэмэгдлийн хувь хэмжээ (үндсэн цалингийн хувиар)** |
|---|---|---|
| Бага цол | Цагдаагийн дэд ахлагч | 25<br><br>/ЗГ-ын 2014 оны 126-р тогтоолоор өөрчилсөн/ |
| | Цагдаагийн ахлагч | |
| | Цагдаагийн ахлах ахлагч | |
| Дунд цол | Цагдаагийн дэслэгч | 30 |
| | Цагдаагийн ахлах дэслэгч | |
| | Цагдаагийн ахмад | |
| Ахлах цол | Цагдаагийн хошууч | |
| | Цагдаагийн дэд хурандаа | |
| | Цагдаагийн хурандаа | |
| Дээд цол | Туслах комиссар | |
| | Дэд комиссар | |
| | Тэргүүн дэд комиссар | |
| | Тэргүүн комиссар | |

----oOo----

Засгийн газрын 2014 оны 99 дүгээр

тогтоолын 4 дүгээр хавсралт

**ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДАД МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН**

**НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

1. Цагдаагийн алба хаагч, ажилтанд цагдаагийн албаны ур чадварын нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Цагдаагийн албаны ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын туршлага, мэргэшлийн түвшинг харгалзан тухайн алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар тооцож олгоно:

| **Нэмэгдлийн хувь**<br>**Шалгуур** | 5 | 10 | 15 | 20 | 25 |
|---|---|---|---|---|---|
| **Ажлын туршлага**<br>**(жилээр)** | 3 | 5 | 10 | 15 | 20 |

3. Энэ журмын 2 дугаарт заасан хугацааг хангасан алба хаагч, ажилтан нь тухайн түвшний мэдлэг чадвар олгох сургалтад суралцаж амжилттай төгссөн байна.

----oOo----